

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦАГААН НОМ-2022

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдан гарсан бөгөөд хуулийн гол зарчмын зохион байгуулалтын шинэчлэл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулахаар болсон явдал юм.

Үндэсний зөвлөл нь:

- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр, холбогдох дүрэм, журмын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг оновчтой болгоход чиглэсэн үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт дэвшил, дэвшилтэт техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар үүрэг, чиглэл өгөх, зөвлөмж гаргах, ажлын хэсэг байгуулах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, чиглэл өгөх, тайлан мэдээ гаргах;
- замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, захиргааны шийдвэр, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, шаардлага тавих;
- байгууллага, албан тушаалтнаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөгөө үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх, түгээхийг үүрэг болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дээрх эрх, үүргийн дотор багтаж буй Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хуулийн 10 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн бөгөөд энэхүү бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:

- тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан /Автотээврийн үндэсний төв ТӨҮГ/-д механикжсан тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, ашиглалт, засвар, оношилгооны бүртгэл, мэдээллийг хамруулах;
- зам, замын байгууламжийн эвдрэл, гэмтлийн бүртгэл, мэдээллийн сан /Зам, тээврийн хөгжлийн төв/-д замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй зам, замын байгууламжийн төлөв байдал, эвдрэл, гэмтлийн бүртгэл, мэдээллийг хамруулах;

- жолоочийн бүртгэл, мэдээллийн сан /Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл мэдээллийн төв/-д жолоодох эрхийн үнэмлэх дээрх мэдээллийн бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн сан /ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт/-д жолооч бэлтгэх сургалтын байгууллага, түүний сургалтын материаллаг бааз, хүний нөөц болон суралцагсдын бүртгэл, мэдээллийг хамруулах;
- зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан /Тээврийн цагдаагийн алба/-д зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолоочийн эрүүл мэнд, зам тээврийн осолд өртсөн хүний бүртгэл, мэдээллийн сан /Эрүүл мэндийн яам/-д механикжсан тээврийн хэрэгслийн жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэл, мэдээллийг хамруулах;
- жолоочийн даатгалын мэдээллийн сан /Албан журмын даатгагчдын холбоо/-д даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад бүртгэл, мэдээллийг хамруулах;
- авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бүртгэл, мэдээллийн сан Татварын ерөнхий газр/-д тухайн төрлийн татварын бүртгэл, мэдээллийг хамруулах.
- хяналтын төхөөрөмжийн хяналт, зохицуулалтын бүртгэл, мэдээллийн сан /Зам, тээврийн хөгжлийн яам/-д хяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төхөөрөмжийн засвар, үйлчилгээний байгууллагын бүртгэл, ашиглалт, засварын түүх, картын бүртгэл, мэдээллийг хамруулах.

Хуулийн 10.3-т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Үндэсний зөвлөл батлахаар заасны дагуу “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лаавлагаа өгөх журам”-ыг Үндэсний зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар баталж, 01 дугаар тогтоол гаргасан. Журмын 2.3-т зааснаар бүртгэл, мэдээллийн санг хөтлөх Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Албан журмын даатгагчдын холбоо зэрэг байгууллага сар бүрийн 20-ны өдөр мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг ирүүлэх бөгөөд эдгээр мэдээллийг нэгтгэн сарын эмхэтгэл мэдээлэл болгож, албан хэрэгцээнд ашиглаж байна.


ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦАГААН НОМ

Нэг. Автотээврийн хэрэгслийн мэдээлэл

1.1. Тээврийн хэрэгслийн тоон мэдээлэл:

Албаны эх сурвалжаас харахад Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 10 жил тогтвортой өсөж байгаад сүүлийн 5 жилд онцгой их хурдацтайгаар өсөн нэмэгдсэн болохыг зураг 1-ээс харж болно.

Зураг 1. Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо



Өнөөдрийн байдлаар насанд хүрсэн 3 хүн тутамд нэг автомашин оногдох болсон. 2022 оны тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллээс харахад Монгол Улсад нийт 1.264.542 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 711.835 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Нийт тээврийн хэрэгслийн 64,2 хувь буюу 811.910 нь суудлын автомашин эзэлж байна. Ачааны автомашин 222.242, автобус 31.517, тусгай зориулалтын автомашин 14.386, зүтгүүр 43.734, механизм 17.596, чиргүүл 64.123, мотоцикл 54.819 тус тус бүртгэгдсэн. Монгол Улсад нийт тээврийн хэрэгслийн 89,2% буюу 1.128.004 автомашин байгаа ба үүнээс зүүн гар талдаа жолооны хүрдтэй буюу замын баруун талаар явахад зориулагдсан 451,107 (40%), баруун гар талдаа жолооны хүрдтэй буюу замын зүүн гар талаар явахад зориулагдсан 676,706 (60%) тээврийн хэрэгсэл тус тус бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотын хэмжээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй 433,305 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн ба энэ нь нийт Улаанбаатарт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 60,8% эзэлж байна.

Бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 58.465 буюу 5% нь 0-3 жил, 44.051 буюу 3% нь 4-6 зургаан жил, 117.225 буюу 9% нь 7-9 жил, 1.044.801 буюу 83 % нь 10 болон


түүнээс олон жил тус тус ашиглагдаж байна. 2021 онд бүртгэлтэй байгаа 10 болон түүнээс олон жил ашиглагдсан тээврийн хэрэгслийн тоо өмнөх оныхоос 4%-иар өссөн мэдээ байна. Харин 0-3 жил ашиглагдсан тээврийн хэрэгслийн тоо 2012 оноос хойш тасралтгүй буурсаар 2022 онд ялимгүй өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Авто тээврийн хэрэгслийн насжилт




Монгол улсад сүүлийн 4 жилд нийт 389,669 тээврийн хэрэгсэл импортоор орж ирсэн бол 95,727 тээврийн хэрэгсэл ашиглалтаас хасагдсан байна.


Зураг 3. Сүүлийн 4 жилд импортоор орж ирсэн болон ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн тоо



Зураг 4. Сүүлийн 4 жилд ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн тоо




Зураг 5. Сүүлийн 4 жилд импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийн тоо



Монгол улсад 2019 онд 4196 бүрэн бус, эвдрэл, гэмтэлтэй тээврийн хэрэгсэл импортлогдсон байна. Энэ нь 2019 онд импортлогдсон нийт автомашины 4%-ийг эзэлж байна. Эдгээр тээврийн хэрэгслийн 20.1% нь хөдөлгөөний идэвхтэй аюулгүй байдалд нөлөөлөх эд ангийн эвдрэл, 67.07% нь хөдөлгөөний идэвхгүй аюулгүй байдалд

нөлөөлөх эд ангийн эвдрэл, гэмтэл, 12.7% нь бусад төрлийн буюу үерийн усанд орсон, асдаггүй, мөргөлдсөн, мөндөрт цохиулсан гэх мэт эвдрэл гэмтэлтэй байна.

Зураг 6. 2019 онд импортоор эвдрэл, гэмтэлтэй орж ирсэн 4196 тээврийн хэрэгсэл эвдрэл, гэмтлийн ангиллаар



“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас технологийн эрин зуунд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор Бельги улсын Бруссель хотод байрладаг “The International Motor Vehicle Inspection Committee” буюу “CITA” Техникийн Хяналтын Олон Улсын Хорооны албан ёсны гишүүнээр 2017 онд элссэн. Тус хороо нь Дэлхийн 60 гаруй орны техникийн хяналтын үзлэг явуулдаг 150 орчим байгууллагын гишүүнчлэлтэй ашгийн төлөө бус

байгууллага бөгөөд тээврийн хэрэгсэл (чиргүүл), тэдгээрийн техник ашиглалт, тогтоосон давтамжийн дагуу хийгдэх техникийн хяналт үзлэгтэй холбоотой ажил үйлчилгээний чанар, бүтээмж, үр ашгийг шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаанд тулгуурлан дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж зэрэгт нийцүүлэн санал боловсруулах, хөгжүүлэх чиг үүрэгтэй НҮБ-ын Европын эдийн засгийн хороонд зөвлөх статустай байгууллага юм. Тус хороо нь техникийн хяналтын үзлэгийг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр 25 зөвлөмжийг гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг орчуулан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал



Тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахдаа 10 стандартын 160 гаруй шалгуур үзүүлэлтээр үздэг бөгөөд 2022 онд улсын хэмжээнд нийт 797726 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсанаас 10941 тээврийн хэрэгсэл бага зэргийн гэмтэлтэй тэнцсэн бол анхны үзлэгээр тэнцээгүй 45889 тээврийн хэрэгслээс 34948 тээврийн хэрэгсэл шаардлагатай засвар, техникийн үйлчилгээ хийж дахин үзлэгт хамрагдаж тэнцсэн ба өнөөгийн байдлаар тэнцээгүй 10941 тээврийн хэрэгсэл байна.

/График-2. Үзлэгт тэнцээгүй үзүүлэлтээр



Эх сурвалж: АТҮТ – Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сан

1.2 Монгол улсын улс, хот хоорондын нийтийн зорчигч тээвэр

1.2.1 Улс хоорондын зорчигчийн тогтмол тээвэрлэлт

Улс хоорондын зорчигчдын тогтмол тээвэрлэлтийг ОХУ, БНХАУ, БНКазахстан гэсэн 3 улсын 10 чиглэлд 13 аж ахуйн нэгж, байгууллагын 90 тээврийн хэрэгсэл, 162 мэргэшсэн жолоочтойгоор /давхардсан тоогоор/ тээвэрлэлт гүйцэтгэж байна. 2023.02.28-ны байдлаар 1810 тээврийн хэрэгслээр 45545 зорчигч улс хоорондын зорчигчдын тогтмол тээврийн чиглэлээр зорчсон байна.




График1. Улс хоорондын зорчигч урсгал



1.2.2 Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ зохицуулалт, зохион байгуулалт

Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 58 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 49 чиглэлд 800 тээврийн хэрэгсэл, 1477 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Хот хоорондын чиглэлд 2023 оны 01 дүгээр сарын байдлаар 1321.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 44.9%-иар өссөн үзүүлэлттэй байна.



График 2. Хот хоорондын зорчигч урсгал

Мэдээллийн санд хамрагдсан тээврийн хэрэгслүүдийг төрлөөр нь ангилахад 45 хүний суудалтай том оврын автобус 607, 24-36 хүний суудалтай дунд оврын автобус 36, суудлын автомашин 157 буюу нийт 800 тээврийн хэрэгсэл байна.



Хот хоорондын нийтийн зорчигч тээвэрт явж буй тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: том оврын тээврийн хэрэгсэл 76%, дунд овор 4%, суудлын тээврийн хэрэгсэл 20%-ийг тус тус эзэлж байна.

График 3 Тээврийн хэрэгслийн судалгаа

1.2.3 Жуулчин тээвэр

Жуулчин тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээг 2022 оны жилийн эцсийн байдлаар 28 аж ахуйн нэгж байгууллага, 16 иргэнтэй гэрээ байгуулан 128 тээврийн хэрэгсэлд жуулчин таних тэмдэг /TOURIST наалт/-ийг олгон ажиллаж байна.

Жуулчин тээврийн үйлчилгээ төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системд нэгдсэнтэй холбоотой төрийн цахим үйлчилгээний <http://e-mongolia.mn> системээр дамжуулан жуулчин таних тэмдэг / TOURIST/ авах хүсэлтүүдийг авч эхлээд байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “МОНГОЛД ЗОЧЛОХ ЖИЛ” болгож зарласантай холбогдуулан жуулчин тээврийн үйл ажиллагаа эрхлэгч ААН байгууллага болон иргэдэд онол, практик хосолсон сургалт зохион байгуулж сургалтаар жуулчин тээврийн үйлчилгээ e-mongolia нэгдсэн порталт нэгдсэн талаар танилцуулан уг порталтаар хэрхэн үйлчилгээ авахыг танилцуулан ажиллаж байна.

1.2.4 Орон нутгийн нийтийн тээвэр

Орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 28 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 6 аймгийн 48 чиглэлд тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Орон нутгийн нийтийн тээврээр 2022 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 412,0 мянган зорчигч тээвэрлэсэн байна. Орон нутгийн тээвэрлэлтийг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах, бүртгэлжүүлэх, хяналт тавих зорилгоор салбар төвүүдэд чиглэл өгч, онлайн уулзалт зохион байгуулан ажиллаж байна.

1.2.5 Улс хот хоорондын ачаа тээвэр


“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Зам, тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан 76 дугаар тушаалын дагуу улс, хот хоорондын ачаа, илгээмжийн ачаа болон тээш тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах ажлын хүрээнд “Тээврийн нэгдсэн систем”-ийг 2019 оны 3-р улирлаас үйл ажиллагаандаа ашиглаж хил нэвтрэх зорчих зөвшөөрлийн бичгийг олгон ажиллаж байна. Тус системд бүртгэлтэй тээврийн нийт 490 аж ахуйн нэгж байгууллагын 28734 тээврийн хэрэгсэл, 28734 жолооч байна.

2022 онд БНХАУ-тай хиллэдэг авто замын Баянхошуу, Бичигт, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Бургастай, Булган, ОХУ-ын Алтанбулаг, Цагааннуур, Боршоо боомтуудаар улс хоорондын ачаа тээвэрлэлт хийгдсэн.

Хүснэгт 1. Хилийн боомтуудад үйл ажиллагаа явуулж буй ААНБ, тээврийн хэрэгслийн тоо:

№	Тээвэрлэлтийн чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Тээврийн хэрэгслийн тоо
1	Өмнөговь аймгийн Гашуун сухайт-Ганц мод боомтын чиглэлд	313	21926

2	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгойн уурхайгаас Гашуун сухайт-Ганц мод боомтын чиглэлд	4	240
3	Өмнөговь аймгийн Гурван тэс сум Овоот толгой МАК, Хүрэншанд болон Терра Энержи ХХК-ийн Баруун ноён уул нүүрсний уурхайгаас Шивээ хүрэн - Сэхээ боомтын чиглэлд	63	3219
4	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Айлбаянгийн уурхайгаас Ханги - Мандал боомтын чиглэлд	34	933
5	Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас -Эрээн боомтын чиглэлд	10	384
6	Дорнод аймгийн Матад сумын Хөөтийн нүүрсний уурхайгаас болон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт - Зүүн хатавч боомтын чиглэлд	21	407
7	Дорнод Матад сумын Тамсагийн сав газраас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт - Зүүн хатавч боомтын чиглэлд	2	31
8	Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газраас Баянхошуу - Өвдөгт боомтын чиглэлд	2	105
9	Ховд аймгийн Дарви сумын Хөшөөтийн уурхайгаас Булган сумын Булган Такашкен боомтын чиглэлд	40	1317
10	Говь-Алтай аймгийн Цээл сумын Таяннуурын уурхайгаас Бургастай - БНХАУ-ын Лаомяо боомтын чиглэлд	1	172
Дүн		490	28734



/Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтоор нүүрс тээвэрлэлтийг мөн үетэй харьцуулахад 2,4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна/


Уул, уурхайн бүтээгдэхүүний экспорт /тээврийн хэрэгслээр/



	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт
■ Нүүрс	18462	44246	73289	60813	196810
■ Төмрийн хүдэр	121	247	8661	7042	16071
■ Зэсийн баяжмал	2291	3651	3388	1965	11295
■ Жонш	6	21	38	13	78
■ Газрын тос	0	373	4785	3412	8570

/Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтоор нүүрс тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн тоо/

Уул, уурхайн бүтээгдэхүүний экспорт /тн.жин/




	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт
■ Нүүрс	1839303	5094137	10357983	8543511	25834934
■ Төмрийн хүдэр	8786	18980	485147	396650	909563
■ Зэсийн баяжмал	91640	146040	135520	76360	449560
■ Жонш	415	1917	2757	962	6051
■ Газрын тос	0	13470	173286	122450	309206

■ Нүүрс ■ Төмрийн хүдэр ■ Зэсийн баяжмал ■ Жонш ■ Газрын тос


/Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, тн.жин, ачааны төрлөөр/

ОХУ-тай хиллэдэг авто замын боомтоор орсон, гарсан тээврийн хэрэгсэл болон ачааны мэдээ



/ОХУ-ын автозамын боомтоор орсон, гарсан тээврийн хэрэгслийн тоо/

Экспортын бүтээгдэхүүний төрлөөр /Автозамаар тээвэрлэсэн/



/БНХАУ-тай хиллэдэг автозамын боомтоор тээвэрлэсэн уул уурхайн бүтээгдэхүүний мэдээ, тн.жин/

Хоёр. Автозамын нөхцөл байдлын мэдээлэл

Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутагтай, дэлхийд газар нутгийнхаа хэмжээгээр 19-д жагсдаг. Монгол Улсад авто замын дэд бүтэц нийт нутгийг хамран төдийлэн сайн хөгжөөгүй тул замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Монгол Улсын авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 111 916.7 км авто замаас бүрддэг. Нийт авто замын сүлжээнээс 4 299.3 км авто зам нь олон улсын, 14 921.3 км нь улсын чанартай авто замд хамаарагдах бөгөөд үүний 7485.6 км нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 898.4 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32/, Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4a, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1a, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 3 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан.

Монгол Улс авто замын сүлжээгээ өргөтгөн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, тэргүүн ээлжинд олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх зорилт тавин, энэ хүрээнд Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 чиглэлийн авто замын сүлжээнд хамаарах Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам буюу Ярант-Ховд-Өлгий-Улаан байшинт чиглэлийн авто замыг хөгжүүлэх, бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтыг авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 онд 21 аймаг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбарын 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг баталж “Нутгийн зам” дэд хөтөлбөр батлан суурин газрыг хатуу хучилттай замаар холбох ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хатуу хучилттай авто замын сүлжээний урт нэмэгдэж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдэж байна. Гэвч баригдсан авто замын сүлжээний ашиглалтын хугацаа уртсаж, норм нормативын дагуу зайлшгүй хийгдэх арчлалт, засварын ажил шаардлагын хэмжээнд хийгдэж чадахгүй байгаагаас авто замд ихээхэн эвдрэл гарч аюулгүй зорчих нөхцлийг хангаж чадахгүйд хүрч байна

Улсын чанартай авто замын хучилтын байдал. Хүснэгт 2.1

Улсын чанартай авто замын хучилтын төрөл	Авто замын урт /км/
а/ Хатуу хучилттай	7485.6
Үүнээс:	
Цемент бетон	8.6

	Асфальт бетон	7 477,0
б/ Хайрган хучилттай		905.7
в/ Сайжруулсан хөрсөн		347.3
г/ Ердийн хөрсөн зам		6 182.7
НИИТ		14 921.3

Улсын чанартай авто замд ашиглаж байгаа гүүрийн хэмжээ. Хүснэгт 2.2

Гүүрүүд		Нийт /ш/	Нийт урт/метр
А: Улсын чанартай замд			
Үүнээс:	Төмөр бетон гүүр	317	14769.57
	Ган гүүр	1	284.0
	Модон гүүр	56	1057.7
Нийт		374	16 111.27

Улсын чанартай авто замын сүлжээ. Зураг 2.1



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн хүчин зүйлийн нэг бол авто замын сүлжээнд аюулгүй зорчих ашиглалтын бэлэн байдлыг хангах асуудал юм. Бэлэн байдлыг хангахад авто замын насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ чухал нөлөөтэй байдаг. /Авто замын насжилт, ашиглалтын байдлын үнэлгээ. Хүснэгт 3, 4./

Авто замын насжилт. Хүснэгт 2.3

№	Хатуу хучилттай авто замын насжилт, жил	Урт, км	Эзлэх хувь, %
---	---	---------	---------------

1	6 жил хүртэл	1264.1	16.9
2	6-13 жил	4227.8	56.5
3	13-аас дээш жил	1993.7	26.6
Нийт		7485.6	100

Улсын чанартай автозамын ашиглалтын байдлын үнэлгээ. Хүснэгт 2.4

Хучилтын байдал	Сайн		Дунд		Муу	
	Урт/км/	%	Урт/км/	%	Урт/км/	%
Цементбетон зам			36.5	100		
Асфальтбетон зам	2844.5	43.3	3170.01	48.2	559.6	8.5
Хөнгөвчилсэн хучилт			137	66.8	68.2	33.2
Хайрган зам			653	70.7	270.56	29.3
Сайжруулсан зам			141.9	53.1	125.3	46.9

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалгаалан авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагатай засвар арчлалтыг хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалт норм, нормативын хэмжээнд хийгдэж чадахгүй байна.

Тухайлбал олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын түвшинг бууруулахгүйгээр байнгын бэлэн байдлыг хангахад нормативын дагуу жилд урсгал засвар, арчлалтад 55.0-60.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай боловч жил бүр улсын төсвийн хөрөнгөөс нийт шаардагдах хөрөнгийн дөнгөж 30-35 хувь /сүүлийн жилүүдэд дунджаар 20 орчим тэрбум төгрөг хуваарилдаг/-ийг шийдвэрлэж байна. Энэ нь жил ирэх тутам засвар, арчлалт бүрэн хийгдэхгүй байгаагаас замын ашиглалтын бэлэн байдлыг хангахад хүндрэлтэй болж байна.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд /UNESCAP, CAREC зэрэг/ нь бүс нутгаараа хамтран эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх зорилгод бүс нутгийг дамнасан авто замын коридоруудыг хөгжүүлэх зорилт тавьсан бөгөөд коридорын дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги, бодлого, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Хамтын ажиллагааны байгууллагуудаас авто замын коридоруудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратегид дэвшүүлж байгаа зорилтуудаас тэргүүн ээлжинд ач холбодол өгч буй зорилтын нэг бол “аюулгүй авто зам” юм. “Аюулгүй авто зам” зорилтын хүрээнд авто замын инженерчлэлийн стандартыг сайжруулах, бүх авто зам хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог нэвтрүүлэх, хар цэгийг тодорхойлж засварлах, авто замын ажлын байран дахь аюулгүй байдлыг сайжруулах зэрэг асуудлыг хөндөн олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бий болгох асуудлыг хамтын ажиллагааны гишүүн орнууд идэвхтэй хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд дэвшлүүлсэн “аюулгүй авто зам” зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах шаардлагатай. Тус зорилтыг төрийн захиргааны болон харьяа байгууллагын үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангаас харахад 2017 онд Монгол Улс нь авто замын дэд бүтцийн чанараараа дэлхийн 140 улсаас 119 дугаарт, Азийн орнуудаас авто замын дэд бүтцийн чанараараа хамгийн мууд тооцогдож байна.

Гурав. Жолооч болон сургалтын байгууллагын мэдээлэл

3.1 Жолооч бэлтгэх сургалтын байгууллага

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/50 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”-ын 4.1.3 дугаар заалт, Монголын авто сургуулиудын багш нарын холбооны удирдах зөвлөл, ажил олгогчдын уулзалтын хурлыг тус тус үндэслэн “Мэргэжлийн зөвлөл байгуулах тухай” Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/09 дугаар тушаалаар Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дэргэдэх “Жолоочийн мэргэжлийн зөвлөл” байгуулагдан, 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/131 дугаар “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.2, 8.4.9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/97, А/231 дүгээр тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2022 онд жолооны мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн хамт нийт 645 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын төвд хяналт үнэлгээ хийсэн.

2022 онд Бүртгэлийн гэрчилгээтэй холбоотой нийт 645 тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын хүсэлт ирснээс:

- Бүртгэлийн гэрчилгээ сунгуулсан 209 байгууллага,
- Шинээр 288 байгууллага.
- Шаардлага хангаагүй буюу түр түдгэлзүүлсэн 111 байгууллагад арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 жолооч бэлтгэх сургалтын байгууллагын бүртгэл, мэдээллийн санд жолооч бэлтгэх сургалтын байгууллага, түүний сургалтын материаллаг бааз, хүний нөөц болон

суралцагсдын бүртгэл, мэдээллийг хамруулах заалтын хүрээнд Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын төв 400 гаран сургалтын байгууллагыг mergejil.mn -д бүртгэлжүүлэн ажилласан.

Захирал, багш нарыг чадавхжуулах, шинэ багш бэлтгэх сургалт талаар:

- 6 удаагийн сургалтаар 188 захирал
- 5 удаагийн сургалтаар 250 багш
- 3 удаагийн сургалтаар 94 багшийг шинэ сургаж бэлтгэсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төдийн даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/38 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журмын шинэчлэх” ажлын байгуулан, нийт 3 удаагийн хурал зохион байгуулан ажилласан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.2.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинэжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн А/97, А/231 дүгээр тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн төгсөлтийн шалгалт авах шалгалтын төвийг үнэлж, дүгнэлт гарах ажлын хэсгийг байгуулан, нийт 4 удаагийн хурал зохион байгуулан, шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.

3.2 Жолооч бэлтгэх сургалт төгсөгчдөөс шалгалт авах үйл ажиллагаа

ЦЕГ-ын БМТ-өөс авах

3.3 Мэргэшсэн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох ажлын хүрээнд:

Монгол Улсын Авто тээврийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ын дагуу мэргэшсэн жолоочийн шалгалтыг зохион байгуулж байна. “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох мэргэжлийн шалгалтын комисс”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.11.04-ний өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.

2022 оны жилийн эцсийн байдлаар 31,439 жолоочоос давхардсан тоогоор 57,938 удаа шалгалт авч 26,958 жолооч шалгалт тэнцсэнээс 14,922 мэргэшсэн жолоочийн үнэмлэх хэвлэж олгосон.

Мэргэшсэн жолоочийн ангилалд:

	<i>Нийт хамрагдсан</i>	<i>Нийт тэнцсэн</i>	<i>Хувь</i>
➤ В ангилал -	929	451	49%
➤ С ангилал -	959	407	42%
➤ Д ангилал -	5136	1816	35%
➤ СЕ ангилал -	29472	11772	40%
НИЙТ	36496	14446	39%

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

➤ Улс хоорондын ачаа тээвэр	19928	11549	58%
➤ Улс хоорондын зорчигч тээвэр	171	106	62%
➤ Жуулчин тээвэрлэлт	240	165	69%
➤ Аюултай ачаа тээвэрлэлт	1103	692	63%
НИЙТ	21442	12512	58%





График 3.1 Мэргэшсэн жолоочийн ангиллын судалгаа

2022 оны жилийн эцсийн байдлаар 14446 жолооч мэргэшсэн жолооч болсон нь өмнөх оны мөн үеэс 0,8% -иар буурсан үзүүлэлттэй байна.

Дөрөв. Зам, тээврийн осол, хэргийн нөхцөл байдал

4.1 Бүртгэгдсэн зам тээврийн осол

Сүүлийн 5 жилийн байдлаар нийт 123147 зам тээврийн осол бүртгэгдсэний 105593 буюу 85.7 хувь нийслэлд, 17554 буюу 14.3 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.




Жич: 2022 оны 100000 хүнд ноогдох зам тээврийн ослын тоог 2021 оны хүн амын тоог тооцож авсан.



Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын хамгийн их буюу 23.0 хувийг Баянзүрх дүүрэг, 18.6 хувийг Баянгол дүүрэг, 18.4 хувийг Сонгинохайрхан дүүрэг, 15.8 хувийг Хан-Уул дүүрэг, 15.2 хувийг Сүхбаатар дүүрэг, 7.9 хувийг Чингэлтэй дүүрэг, 0.9 хувийг Налайх дүүрэг, 0.2 хувийг Багануур дүүрэг, 0.1 хувийг Багахангай дүүрэг тус тус эзэлж байна.

Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн осол /Сүүлийн 5 жилийн байдлаар/




4.2 Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан

Нийт бүртэгдсэн зам тээврийн ослын 120000 буюу 97.4 хувийг жолоочийн буруутай үйлдлээс, 292 буюу 0.2 хувийг замын нөхцөлөөс, 2855 буюу 2.3 хувийг явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол эзэлж байна.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын дийлэнх хувийг:

- Хажуу хоорондын зай тохируулаагүй-51296 буюу 41.7%
- Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн-20357 буюу 16.5%
- Эгнээ байр буруу эзэлсэн-13017 буюу 10.6%
- Ухрах үйлдэл буруу хийсэн-8572 буюу 7.0%
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-5569 буюу 4.2%-г тус тус эзэлж байна.



Жолоочийн буруутай үйлдлийн шалтгаан


Шалтгаан	Тоо	Эзлэх хувь
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	5569	4.5
Хурд хэтрүүлсэн	5116	4.2
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	806	0.7
Анхаарал болгоомжгүй	6185	5.0
Зогсоох арга хэмжээ аваагүй	3267	2.7
Уулзвар гарч нэвтрэх журам зөрчсөн	20357	16.5
Гэрэл дохио	1133	0.9
Эргэх үйлдэл буруу	450	0.4
Зай тохируулаагүй	51296	41.7
Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	1837	1.5
Эсрэг урсгалд орсон	948	0.8
Эгнээ байр буруу эзэлсэн	13017	10.6
Хүн ба ачаа тээврийн журам зөрчсөн	413	0.3
Ухрах үйлдэл буруу хийсэн	8572	7.0
явган хүний гарцтай замар зам хөндлөн гарч хэргийн газраас зугтаасан	521	0.4
92	0.1	
Бусад	3568	2.9

Орон нутагт хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан ослын дийлэх хувийг 417 буюу 25.5 хувийг Төв аймаг, 356 буюу 21.8 хувийг Өмнөговь аймаг, 179 буюу 10.9 хувийг Хэнтий аймаг, 86 буюу 5.3 хувийг Сүхбаатар аймаг, 80 буюу 4.9 хувийг Дорноговь аймаг тус тус эзэлж байна.


Орон нутагт хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан осол /сүүлийн 5 жил/



Орон нутагт хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан осол /сүүлийн 5 жил/



Орон нутагт согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан зам тээврийн ослын дийлэнх хувийг 279 буюу 11.6 хувийг Хэнтий аймаг, 190 буюу 7.9 хувийг Сэлэнгэ, 151 буюу 6.3 хувийг Дорноговь, 147 буюу 6.1 хувийг Ховд аймаг, 144 буюу 6.0 хувийг Хөвсгөл аймаг тус тус эзэлж байна.




Хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан ослын ихэнх хувийг Нийслэлийн Баянзүрх дүүрэгт гарсан ослууд эзэлж байна.

4.3 Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол:


Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол нь нийт ослын 292 буюу 0.2 хувийг эзэлж байна.

Замын нөхцлөөс шалтгаалсан ослын голлох шалтгаан нь замын гадаргуу халтиргаатай, эвдрэлтэй, тэмдэг тэмдэглэлгээ ойлгомжгүй байснаас үүдэн гардаг бол техникийн гэмтэл сааталд жолоочоос хамааралгүй тухайлбал жолооны хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, хөдөлгүүр эвдэрч гэмтэснээс шалтгаалсанаас гарсан ослууд багтана.



4.4 Явган ба дугуйтай хүний буруугаас шалтгаалсан осол:

Явган ба дугуйтай хүний буруугаас шалтгаалсан осол нийт ослын 2855 буюу 2.3 хувийг эзэлж байна. Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэмд “Үзэгдэх хүрээнд явган хүний гарц ба гарам байхгүй бол замын дагуу хоёр тийш сайн харагдах, саадгүй хэсгээр ойртон ирж яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэн эгц хөндлөн гарна” гэж заасан байдаг. Явган хүний гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарах тохиолдолд явган зорчигчид давуу эрх олгогдохгүй. Хэрвээ явган зорчигч үзэгдэх орчинд гарц байсаар байтал гарцгүй хэсгээр зам хөндлөн гарч байхгүй үедээ зам тээврийн осолд өртвөл явган зорчигчийн буруу болно. Түүнчлэн гарах хохирлыг өөрөө хариуцах юм.




Явган ба дугуйтай хүний буруугаас шалтгаалсан ослын сүүлийн 5 жилийн байдлаар:


- Явган ба дугуйтай хүний буруугаас шалтгаалсан осол 1503 буюу 52.6%,
- Явган зорчигч согтуугаар хөдөлгөөнд оролцсон 1080 буюу 37.8%,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр хөдөлгөөнд оролцуулсан осол 272 буюу 9.5%-г тус тус эзэлж байна.

4.5 Зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүн

Монгол улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас сүүлийн 5 жилд 19098 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна. Зам тээврийн ослоор 2475 хүн амь нас алдсан бөгөөд 1891 буюу 76.4 хувь орон нутагт, 584 буюу 23.6 хувь нийслэлд бүртгэгдсэн байна.




Орон нутагт зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний ихэнхи хувийг Төв аймаг 248 буюу 13.1 хувийг, Өмнөговь аймаг 151 буюу 7.9 хувийг, Өвөрхангай аймаг 117 буюу 6.2 хувийг, Дорноговь аймаг 113 буюу 5.9 хувийг, Хөвсгөл аймаг 109 буюу 5.8 хувийг тус тус эзэлж байна.



Нийслэлд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн:


- ✚ Сонгинохайрхан дүүрэг хамгийн их 204 буюу 34.9%
- ✚ Хан-Уул дүүрэг 110 буюу 18.8%
- ✚ Баянзүрх дүүрэг 99 буюу 17.0%
- ✚ Сүхбаатар дүүрэг 46 буюу 7.9%
- ✚ Чингэлтэй дүүрэг 44 буюу 7.5%
- ✚ Баянгол дүүрэг 38 буюу 6.5%
- ✚ Налайх дүүрэг 28 буюу 4.8%
- ✚ Багануур дүүрэг 12 буюу 2.1%
- ✚ Багахангай дүүрэг 3 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Амь насаа алдсан хүнийг хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр нь авч үзвэл:



4.6 Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн:

Зам тээврийн ослын улмаас сүүлийн 5 жилд 16623 хүн хөнгөн, хүнд зэргийн гэмтэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна.




Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүнийг хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр нь авч үзвэл:

- ❖ Явган зорчигч 8228 буюу 49.5 хувь
- ❖ Зорчигч 5487 буюу 33.0 хувь
- ❖ Жолооч 2485 буюу 14.9 хувь
- ❖ Дугуйтай хүн 422 буюу 2.5 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний ихэнх хувийг Төв аймаг 888 буюу 17.3 хувийг, Архангай аймаг 349 буюу 6.8 хувийг, Дархан-Уул аймаг 344 буюу 6.7 хувийг Дорнод аймаг 341 буюу 6.6 хувийг, Сэлэнгэ 324 буюу 6.3 хувийг эзэлж байна.

Орон нутаг зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн

/2018-2022/




Нийслэлд зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн:

- ❖ Баянзүрх дүүрэг хамгийн их 2637 буюу 22.9%
- ❖ Сонгинохайрхан дүүрэг 2548 буюу 22.2%
- ❖ Баянгол дүүрэг 1672 буюу 14.5%
- ❖ Сүхбаатар дүүрэг 1605 буюу 14.0%
- ❖ Хан-Уул дүүрэг 1597 буюу 13.9%
- ❖ Чингэлтэй дүүрэг 1169 буюу 10.2%
- ❖ Налайх дүүрэг 171 буюу 1.5%
- ❖ Багануур дүүрэг 81 буюу 0.7%
- ❖ Багахангай 19 буюу 0.2-г тус тус эзэлж байна.

Нийслэлд зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн

/2018-2022/




4.6 хүүхэд өртсөн осол

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар хүүхэд өртсөн осол 3470 бүртгэгдсэнээс 3915 хүүхэд амь нас эрүүл мэндээрээ хохирсон байна.


Д/д	Он	Нийт бүртгэгдсэн зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Үүнээс:	
				Нас барсан хүүхэд	Гэмтэж бэртсэн хүүхэд
Улсын хэмжээнд					
1	2018	940	1049	45	1004
2	2019	745	819	49	770
3	2020	543	624	63	561
4	2021	463	537	51	486
5	2022	779	886	76	810
Нийт		3470	3915	284	3631

Хүүхэд өртсөн зам тээврийн ослын 32.8 хувийг орон нутагт, 67.2 хувийг нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн осол эзэлж байна.



Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүүхдийн хөдөлгөөнд оролцсон хэлбэрийг авч үзвэл 2438 буюу 62.3 хувь нь явган зорчигч хэлбэрээр, 1193 буюу 30.5 хувь нь зорчигч хэлбэрээр, 197 буюу 5.0 хувь нь унадаг дугуйтай, 87 буюу 2.2 хувь бусад /жолооч/ хэлбэрээр хөдөлгөөнд оролцсон байна.

Хүүхэд өртсөн зам тээврийн ослын үзүүлэлт




Нийслэлд хүүхэд өртсөн ослын 67.2 хувь нь, гэмтсэн хүүхдийн 70.3 хувь нь, амь насаа алдсан хүүхдийн 16.5 хувийг эзэлж байна. Амь насаа алдсан хүүхдийн 83.5 хувь нь орон нутагт гарсан осол эзэлж байгаа нь суудлын бүс зүүгээгүй, хурд хэтрүүлсэн, хүүхдүүд харгалзах хүнгүйгээр хөдөлгөөнд оролцох нь зам тээврийн осолд өртөх гол шалтгаан болж байна.

4.7 Зам тээврийн ослын хэлбэр

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 102406 буюу 83.2% нь мөргөлдөх, 8685 буюу 7.1% нь явган хүн дайрсан, 4887 буюу 4.0% нь онхолдох, 4858 буюу 3.9% нь үл хөдлөх зүйл мөргөсөн, 953 буюу 0.8% нь мал амьтан дайрсан, 492 буюу 0.4 хувийг дугуйтай хүн дайрсан, 202 буюу 0.2% нь зорчигч унагасан, 664 буюу 0.5% нь бусад хэлбэрээр тус тус бүртгэгдсэн байна.

Онхолдох	Мөргөлдөх	Явган хүн дайрсан	Дугуйтай хүн дайрсан	Үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал, амьтан дайрсан	Бусад
4887	102406	8685	492	4858	202	953	664
4.0	83.2	7.1	0.4	3.9	0.2	0.8	0.5



4.8 Осол бүртгэгдсэн гараг, цаг

Зам тээврийн осол гарсан гараг:

- ✓ Даваа гараг 18484 буюу 15.0%
- ✓ Мягмар гараг 18024 буюу 14.6%
- ✓ Лхагва гараг 18659 буюу 15.2%
- ✓ Пүрэв гараг 18045 буюу 14.7%
- ✓ Баасан гараг 18765 буюу 15.2%
- ✓ Бямба гараг 16252 буюу 13.2%
- ✓ Ням гараг 14918 буюу 12.1%-г тус тус бүртгэгдсэн байна

Зам тээврийн осол гарсан цагийг бүлэглэн авч үзвэл:

- 06-14 цагийн хооронд 46287 буюу 37.6%
- 15-19 цагийн хооронд 37032 буюу 30.1%
- 20-22 цагийн хооронд 19852 буюу 16.1%
- 23-06 цагийн хооронд 19976 буюу 16.2% гарсан байна.

4.9. Осол гаргасан тээврийн хэрэгслийн төрөл

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл 106971 буюу 86.9% нь суудлын, 9747 буюу 7.9% нь ачааны, 2543 буюу 2.1% нь том оврын автобус, 169 буюу 0.1% механизм, 2191 буюу 1.8% нь мотоцикл, 527 буюу 0.4% нь унадаг дугуй, 999 буюу 0.8 бага оврын автобус жолоодож яваад зам тээврийн осол гаргасан байна.

Суудлын	Ачааны	Том оврын автобус	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй	Бага оврын автобус
106971	9747	2543	169	2191	527	999
86.9	7.9	2.1	0.1	1.8	0.4	0.8

4.10 ЗТО-ын эрсдлээс хамгаалах хэрэгсэл /бүс, малгай/

Суудлын хамгаалах бүс бол жолооч, зорчигчийг ослын үед гарах гэмтэл, хор уршгаас сэргийлнэ. Автомашины хамгаалах бүсийг зөв хэрэглэвэл жолооч болон зорчигчийн амь нас, эрүүл мэндийг учруулах хор, хохиролыг 40-80 хувиар бууруулж хамгаалдаг.

Хамгаалах бүс хэрэглээгүй зөрчлийн илрүүлэлт /2018-2022/			
Он	Улс	Нийслэл	Орон нутаг
2018	109418	43471	65947
2019	116259	44941	71318
2020	95321	39626	55695
2021	93770	35470	58300
2022	128153	54440	73713

Хамгаалах бүс хэрэглээгүй зөрчлийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд илрүүлэлт нь өсч байгаа үзүүлэлттэй харагдаж байна.




Зам тээврийн ослын улмаас амь нас эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн хамгаалах бүсний хэрэглээг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд хамгаалах бүс хэрэглэсэн 20.0 хувь, хэрэглээгүй 65.0 хувь, 15.0 хувь нь хамгаалах бүс хэрэглэсэн эсэх нь тогтоогдоогүй байна.

Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн хамгаалах бүсний хэрэглээ

Он	Хэрэглэсэн	Хэрэглээгүй	Тогтоогдоогүй
2018	17.2%	67.1%	15.7%
2019	15.9%	59.3%	24.8%
2020	23.4%	72.9%	3.7%
2021	29.9%	58.4%	11.7%
2022	14.2%	66.2%	19.5%

Хамгаалах малгай хэрэглээгүй замын хөдөлгөөнд оролцсон зөрчил:

Мотоцикл, модоор замын хөдөлгөөнд оролцож буй тохиолдолд зориулалтын хамгаалалтын малгайг зааврын дагуу өмсөж хэрэглэснээр ослын үед амь насаа алдах эрсдэлийг 40 хүртэл хувиар бууруулж чадна гэж олон улсад үздэг байна.



4.11 Хурд хэтрүүлсэн зөрчил, осол

Замын хөдөлгөөний дүрэмд суурин газарт 60км/цаг, орон нутгийн замд зорчих дээд хурдыг 80 км/цаг гэж заасан байдаг боловч жолооч нар орон нутгийн замд дүрмээ биелүүлэхгүй хурд хэтрүүлэн замын хөдөлгөөнд оролцох зөрчил их гарч байна.

Хурд хэтрүүлсэн зөрчлийн илрүүлэлт					
Он	2018	2019	2020	2021	2022
Зөрчил илрүүлэлт	67226	71942	150486	116780	255270

Хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан осол сүүлийн 5 жилд нийт 5116 осол бүртгэгдсэний 3480 буюу 68.0 хувь нь нийслэлд, 1636 буюу 32.0 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.



№	Он	ТХХАБАЖЭГэмт хэрэг			Гэмт хэргийн улмаас нас барсан хүн			Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн		
		улс	хот	орон нутаг	улс	хот	орон нутаг	улс	хот	Орон нутаг
1	2018	255	36	219	92	17	75	124	25	99
2	2019	332	51	281	164	14	150	183	38	145
3	2020	195	20	175	86	8	78	109	12	97
4	2021	136	21	115	64	7	57	86	30	56
5	2022	148	21	127	58	1	57	99	20	79


Хурд хэтрүүлсэнээс шалтгаалсан гэмт хэргийн улмаас сүүлийн 5 жилд 464 хүний амь нас хохирч, 601 хүн гэмтсэн байна. Амь насаа алдсан хүний 89.9 хувь нь орон нутагт, 10.1 хувь нь нийслэлд, гэмтсэн хүний 79.2 хувь нь орон нутагт, 20.8 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.

4.12. Мотоцикл холбогдсон осол

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар мотоциклтой холбоотой зам тээврийн осол 2462 бүртгэгдсэний 1936 буюу 78.6 хувь орон нутагт бүртгэгджээ. Мотоцикл холбоотой осол орон нутагт онхолдох хэлбэрээр ихээхэн гарч байгаа ба мотоциклын жолооч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ мотоцикл жолоодон хөдөлгөөнд оролцож онхолдох, жалганд унах зэрэг хэлбэрээр осол их гарч байна

№	Он	Мото холбогдсон осол			Мото холбогдсон ослын улмаас нас барсан хүн			Мото холбогдсон ослын улмаас гэмтсэн хүн		
		хот	орон нутаг	улс	хот	орон нутаг	улс	хот	орон нутаг	улс
1	2018	83	469	552	4	112	116	55	210	265
2	2019	86	403	489	3	119	122	66	207	273
3	2020	92	387	479	4	70	74	66	229	295
4	2021	135	327	462	6	87	93	76	170	246
5	2022	130	350	480	2	118	120	73	169	242
Нийт		526	1936	2462	19	506	525	336	985	1321

Мотоцикл холбогдсон зам тээврийн ослын улмаас 525 хүн амь насаа алдаж, 1321 хүн эрүүл мэндээрээ хохирсон байна.




Орон нутагт мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн ослын ихэнх хувийг Өвөрхангай аймаг 174 буюу 9.0 хувийг, Төв аймаг 168 буюу 8.7 хувийг, Өмнөговь аймаг

132 буюу 6.8 хувийг, Баянхонгор аймаг 125 буюу 6.5 хувийг, Сүхбаатар аймаг 120 буюу 6.2 хувийг эзэлж байна

Тав. Эрүүл мэнд салбарын мэдээлэл


5.1 Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл /v01-v99/

2022 онд 21128 хүн зам тээврийн ослын улмаас гэмтэж, энэ нь 2021 оноос 32.4%-иар өссөн байна. Зам тээврийн осол нь осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны нэг бөгөөд 10 000 хүн тутмын 58.3 нь энэхүү осолд өртсөн үзүүлэлттэй байна.




Зам тээврийн осолд өртөж байгаа тохиолдлын 64.2%-ийг /13574/, 35.8%-ийг /7557/ эрчүүд эзэлж байна.


2022 онд зам тээврийн ослын улмаас эмнэлгийн тусламж авсан иргэдийн дундаж нас 30.3 ба насны бүлгээр судлахад 10-14 болон 30-34 насанд тохиолдлыг тоо хамгийн их байгаа бол тухайн насны 10000 хүн амд ногдох үзүүлэлтээр 20-24 насанд өндөр байна.



5.2 Зам тээврийн ослын тэргүүлэх 5 шалтгаан /2022 оноор/










Зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 32.9%-ийг жолооч, 28.0%-ийг зорчигч, 23.5%-ийг явган зорчигч эзэлж байгаа бол 15.3% нь морь мал унаж явсан байна.



Явганаар болон унадаг дугуй, автобусаар явж байхдаа зам тээврийн осолд орсон тохиолдлуудад зөөлөн эдийн гэмтэл, суудлын болон ачааны машинтай явж байсан тохиолдлуудад гавал тархины доторх гэмтэл мотоцикл болон морь унаж яваад осолд орсон тохиолдлуудад ясны хугарлын гэмтлүүд зонхилон тохиолдож байна.

Хүснэгт 5.1. Зам тээврийн ослоор эмнэлэгт хандсан иргэдийн гэмтлийн төрөл, тээврийн хэрэгслийн төрлөөр


№	 V00-V09	 V10-V19	 V20-V39	 V40-V49	 V50-V69	 V70-V79	 V80
1	Зөөлөн эдийн/г 48.3%	Зөөлөн эдийн/г 43.9%	Хугарал 35.0%	Гавал доторх/г 40.0%	Гавал доторх/г 29.0%	Зөөлөн эдийн/г 50.5%	Хугарал 44.3%
2	Гавал доторх/г 21.7%	Хугарал 24.1%	Зөөлөн эдийн/г 22.5%	Зөөлөн эдийн/г 29.3%	Хугарал 26.8%	Гавал доторх/г 17.5%	Зөөлөн эдийн/г 23.6%
3	Хугарал 15.1%	Шарх 13.5%	Гавал доторх/г 20.0%	Хугарал 14.9%	Зөөлөн эдийн/г 26.3%	Хугарал 16.8%	Гавал доторх/г 15.5%
4	Шарх 6.5%	Гавал доторх/г 12.6%	Шарх 11.9%	Шарх 6.4%	Шарх 7.2%	Бусад 5.1%	Шарх 7.1%
5	Бусад 3.9%	Мултрах, сунах 2.9%	Мултрах, сунах 4.2%	Бусад 3.8%	Бусад 3.7%	Шарх 5.1%	Мултрах, сунах 4.1%

2022 онд зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 7.8% /1641/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байгаа ба тээврийн хэрэгслийн төрлөөр харвал мотоциклтой зорчигчийн согтуу үедээ осолд өртсөн хувь бусад тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 5.2. Зам тээврийн осолд өртсөн иргэдийн согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар

Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	Тээврийн хэрэгслийн төрөл						
	V01-V09 (Явган)	V10-V19 (Дугуй)	V20-V39 (Мотоцикл)	V40-V49 (Суудлын машин)	V50-V69 (Ачааны машин)	V70-V79 (Нийтийн тээвэр)	V80-V80.9 (Морь)
	Хувиар						
Тийм	9.5	0.9	16.4	5.7	8.2	0.9	3.2
Үгүй	90.5	99.1	83.6	94.3	91.8	99.1	96.8


Суудлын машинтай явж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдлын 22.8%-д, ачааны машинтай явж байсан тохиолдлын 24.2% нь суудлын хамгаалах бүстэй байсан гэсэн өгүүлэмжтэй байна.




Улирлаас хамаарсан ялгаа ажиглагддаг осол гэмтлийн шалтгааны нэг нь зам тээврийн осол юм. 2022 оны зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн 35.4% нь зуны улиралд тохиолдсон байна.

Зам тээврийн осолд өртсөний улмаас эмнэлэгт хандах тохиолдол 7 сард бусад саруудтай харьцуулахад өндөр байна

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн улирлаар




Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн сараар



Зам тээврийн осолд өртөж буй гарагаар авч үзвэл даваа болон баасан гаргт бусад өдрүүдээс их байна.

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн гарагаар



Нийт тохиолдлын 69.7% нь нийслэлд, 30.3% нь орон нутагт бүртгэгдсэн байгаа ба нийслэлд тохиолдлын түвшин орон нутгаас 3 дахин өндөр байхад нас баралтын түвшин орон нутагт нийслэлээс 2 дахин өндөр байна.

Хүснэгт 5.3 Зам тээврийн осол бүртгэгдсэн харъяаллаар, 10000 хүн амд

Бүртгэгдсэн газар	Шинэ тохиолдол		Тохиолдлын түвшин	Нас баралтын түвшин
	Бодит тоо	Хувь		
Нийслэл	14731	69.7%	95.7	0.8
Орон нутаг	6397	30.3%	36.1	1.9


Суудлын машины осол нийслэл болон улсын дүнгээр тэргүүлж байгаа болон орон нутагт мотоциклтой зорчигчийн осол тэргүүлж байна. Явган явж байгаад зам тээврийн осолд орж гэмтэх тохиолдол нийслэл болон улсад эзлэх хувиар 2-рт байгаа бол орон нутагт 4-р шалтгаан болсон байна. Мөн эрүүл мэндийн салбарт онцлогоор бүртгэгддэг мориноос унаж гэмтэх тохиолдол нийслэл болон орон нутагт 3-рт орж байна.

Хүснэгт 5.4 Зам тээврийн осол бүртгээгдсэн харъяалал, тээврийн хэрэгслийн төрлөөр

Тээврийн хэрэгслийн төрөл	Орон нутаг	Нийслэл	Улсын дүнгээр
	1	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 34.4%	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 36.8%
2	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 29.3%	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 30.9%	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 23.5%
3	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 25.3%	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 11.6%	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 17.3%
4	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 6.5%	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 9.9%	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 15.7%
5	Ачааны машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 2.2%	Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 7.0%	Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 5.5%

Зам тээврийн осол Архангай, Хөвсгөл аймагт тэргүүлж Хангайн бүсэд хамгийн олон тохиолдсон бүртгэгдсэн байна.

Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгээгдсэн аймаг, бүсээр



2022 онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 464 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 0.9%-р буурсан үзүүлэлттэй байна. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт нь нийт нас баралтын 13.8%-ийг эзэлдэг бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгааны 3-рт орсон байна. Зам тээврийн ослоор амь насаа алдсан нийт тохиолдлын 78% нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 10 000 эрэгтэй тутамд ногдох нас баралтын түвшин 2.2 тохиолдол байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдлын тоо болон өсөлтийн хувь өмнөх онуудаас буурсан байна. Гэсэн хэдий ч 2022 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 31.2% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нас барсан байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг насны бүлгээр харвал 30-34 насанд хамгийн их тохиолдол бүртгэгдэж, 50-54 насанд 10 000 хүн амд ногдох нас баралт 2.9 тохиолдлоор хамгийн өндөр байна. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 2021 онд 33.7%-р намрын улиралд хамгийн их бүртгэгдэж байсан бол 2022 онд 31.5%-р зуны улиралд хамгийн их тохиолдол бүртгэгджээ. Улирал бүрт суудлын машинтай явж байх үедээ осолд орж нас барах тохиолдол тэргүүлж байна. Харин өвөл 27.8%, хавар 23.7% нь явган явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол, намар 30.4%, зун 23.3% нь мотоциклтой явж байх үедээ осолд орж нас барсан тохиолдол тэргүүлэх шалтгааны 2 дугаарт орж байна.

Зургаа. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа

6.1 Жолоочийн даатгалын гэрээ, хураамжийн орлого

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниуд 2023 оны 8-р сард 62,245 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 3,724,306,037 төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна. Даатгалын гэрээний хувьд ангиллаар авч үзвэл хувь хүний 41,967, хуулийн этгээдийн 18,087, мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн 1,662, дамжин өнгөрөхийн 529 гэрээ тус тус байгуулагдсан байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоог доорх хүснэгт 6.1-ээс харна уу.

Хүснэгт 6.1. Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамж, өссөн дүнгээр

Д/Д	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн жолооч		Дамжин өнгөрөх		Нийт	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Миг даатгал	5,849	249,006,371	3,158	302,248,473	334	7,540,582	2	334,818	9,343	559,130,244
2	Мөнх даатгал	3,403	149,716,167	1,361	134,862,383	39	869,220	405	41,676,069	5,208	327,123,839
3	Монгол даатгал	4,561	191,506,655	1,647	176,031,714	156	4,428,682	52	5,911,010	6,416	377,878,061
4	Практикал даатгал	3,181	134,971,215	1,441	121,436,251	23	565,042	66	3,114,952	4,711	260,087,460
5	Амар даатгал	1,188	69,692,452	913	108,263,662	163	3,978,974	0	0	2,264	181,935,088
6	Улаанбаатар хотын даатгал	5	256,677	1	89,100	0	0	0	0	6	345,777
7	Номин даатгал	6,622	290,864,617	1,735	159,996,172	130	3,377,219	0	0	8,487	454,238,008
8	Тэнгэр даатгал	1,247	66,712,558	513	53,837,962	32	842,902	0	0	1,792	121,393,422
9	Бодь даатгал	2,870	119,591,341	829	73,139,462	90	2,102,100	3	420,527	3,792	195,253,430
10	Ган зам даатгал	11	486,090	14	1,457,550	0	0	0	0	25	1,943,640

11	Монре даатгал	843	34,795,216	275	26,517,330	59	1,628,220	0	0	1,177	62,940,766
12	Ард даатгал	10,083	483,376,991	2,645	235,309,762	97	2,428,635	1	97,812	12,826	721,213,200
13	Мандал даатгал	433	24,970,357	1,055	99,034,920	15	365,145	0	0	1,503	124,370,422
14	Хаан даатгал	1,022	41,802,246	2,136	185,359,024	507	12,924,365	0	0	3,665	240,085,635
15	Агула даатгал	649	50,168,448	364	45,656,572	17	542,025	0	0	1030	96,367,045
	Нийт	41,967	1,907,917,401	18,087	1,723,240,337	1,662	41,593,111	529	51,555,188	62,245	3,724,306,037

График 6.1. Жолоочийн даатгалын гэрээ /Даатгалын компаниар/





График 6.2. Жолоочийн даатгалын гэрээний хураамжийн харьцаа /гэрээний ангиллаар/ 2023 оны 8-р сар



Жолоочийн даатгалын гэрээг газар нутгийн байршлаар гэрээний тоо, хураамжийн хэмжээг хүснэгт 6.2-оос харна уу.

Хүснэгт 6.2. Жолоочийн даатгалын гэрээ /газар нутгийн байршлаар/

Д/Д	Байршил	Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Архангай	664	23,539,084
2	Баян-Өлгий	992	33,860,346

3	Баянхонгор	1,011	41,346,119
4	Булган	561	20,483,728
5	Говь-Алтай	714	24,539,548
6	Говьсүмбэр	198	8,268,790
7	Дархан-Уул	1,585	71,577,984
8	Дорноговь	1,088	59,141,691
9	Дорнод	1,061	45,377,239
10	Дундговь	343	13,516,486
11	Завхан	592	21,711,295
12	Орхон	2,142	91,491,108
13	Сэлэнгэ	1,170	47,112,793
14	Сүхбаатар	406	17,075,853
15	Төв	733	36,817,977
16	Увс	778	30,837,698
17	Улаанбаатар	41,533	2,741,169,323
18	Ховд	850	49,261,544
19	Хэнтий	690	25,703,470
20	Хөвсгөл	1,022	38,425,404
21	Өвөрхангай	1,038	40,706,189
22	Өмнөговь	1,513	94,264,705
	Нийт	60,684	3,576,228,374

/ Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тоо хураамжийн дүн ороогүй болно./*

6.2 Байгуулагдсан нийт гэрээний тоо, хураамжийн орлого болон цуцлалт

2023 оны 8-р сард гишүүн 15 даатгалын компаниуд нийт 63,281 даатгалын гэрээ байгуулж, 3,792,769,917 төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлж ажилласан байна. Үүнээс хувь хүний жолоочийн даатгалын 584 гэрээ, хуулийн этгээдийн 443 гэрээ, мэргэшсэн С, D ангиллын 4 гэрээ, дамжин өнгөрөх 5 даатгалын гэрээ цуцлагдсан байна. Нийт гэрээний 1,66% буюу 1,036 гэрээ цуцлагдсан байна. Цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн 68,463,880 төгрөг байна.

Хүснэгт 6.3. Нийт гэрээний тоо, хураамжийн орлого

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн жолооч		/Дамжин өнгөрөх/		Нийт	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн	Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Миг даатгал	5,969	255,170,242	3,214	307,502,448	334	7,540,582	2	334818	9,519	570,548,090
2	Мөнх даатгал	3,445	151,639,668	1,381	136,636,103	39	869,220	408	41,914,485	5,273	331,059,476
3	Монгол даатгал	4,643	194,562,469	1,677	179,009,499	157	4,446,832	54	6,403,436	6,531	384,422,236
4	Практикал даатгал	3,199	135,796,151	1,450	122,071,921	23	565,042	66	3,114,952	4,738	261,548,066
5	Амар даатгал	1214	71,303,484	968	115,821,817	163	3,978,974	0	0	2,345	191,104,275
6	Улаанбаатар хотын даатгал	5	256,677	1	89,100	0	0	0	0	6	345,777

7	Номин даатгал	6,723	295,534,373	1,760	162,300,262	131	3,395,369	0	0	8,614	461,230,004
8	Тэнгэр даатгал	1,255	67,031,965	527	55,446,392	32	842,902	0	0	1,814	123,321,259
9	Бодь даатгал	2,903	120,902,218	838	73,729,502	90	2,102,100	3	420,527	3,834	197,154,347
10	Ган зам даатгал	11	486,090	14	1,457,550	0	0	0	0	25	1,943,640
11	Монре даатгал	862	35,564,894	282	27,163,935	59	1,628,220	0	0	1,203	64,357,049
12	Ард даатгал	10,173	487,739,458	2,663	237,414,007	97	2,428,635	1	97,812	12,934	727,679,912
13	Мандал даатгал	437	25,161,427	1,060	99,413,190	15	365,145	0	0	1,512	124,939,762
14	Хаан даатгал	1,041	42,662,349	2,322	198,372,484	509	12,981,620	0	0	3,872	254,016,453
15	Агула даатгал	671	51,979,824	373	46,577,722	17	542,025	0	0	1061	99,099,571
	Нийт	42,551	1,935,791,289	18,530	1,763,005,932	1,666	41,686,666	534	52,286,030	63,281	3,792,769,917

/Хүснэгт №1-ийн гэрээний тоо, хураамжийн орлогоос цуцлагдсан гэрээний тоо дүн ороогүй учир зөрүүтэй болно./

6.3 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 7 даатгалын компаниас **2023 оны 8-р сард** нийт 966 даатгалын тохиолдолд 1,143,361,241 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрийн хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан 948 даатгалын тохиолдолд 1,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан 15 даатгалын тохиолдолд 30,5 сая төгрөгийн нөхөн төлбөр, эрүүл мэндэд хохирол учруулсан 3 даатгалын тохиолдолд 2,4 сая төгрөгийн нөхөн төлбөр тус тус олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг хүснэгт 6.4-өөс харна уу.

Хүснэгт 6.4. Нөхөн төлбөр /даатгалын компани тус бүрээр/

№	Нэрс	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт	
		Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Миг даатгал	101	155,764,150	2	6,539,973	0	0	1	455,000	104	162,759,123
2	Мөнх даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
3	Монгол даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Практикал даатгал	232	235,399,383	3	2,513,058	0	0	0	0	235	237,912,441
5	Амар даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
6	Улаанбаатар хотын даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Номин даатгал	185	197,838,259	0	0	0	0	0	0	185	197,838,259
8	Тэнгэр даатгал	54	75,978,515	2	877,000	0	0	0	0	56	76,855,515
9	Бодь даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	Ган зам даатгал	2	4,528,000	0	0	0	0	0	0	2	4,528,000
11	Монре даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
12	Ард даатгал	287	346,187,061	8	20,589,390	0	0	2	1,980,050	297	368,756,501
13	Мандал даатгал	87	94,711,402	0	0	0	0	0	0	87	94,711,402
14	Хаан даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
15	Агула даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	АЖДХ	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Нийт	948	1,110,406,770	15	30,519,421	0	0	3	2,435,050	966	1,143,361,241

Хүснэгт 6.5. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

№	Хэмжээний интерваль	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	200,000 хүртэл	58	9,306,455
2	200,000-с 500,000	322	110,032,842
3	500,000-с 800,000	179	112,491,840
4	800,000-с 1,000,000	89	78,610,106
5	1,000,000-с 1,499,999	96	116,360,449
6	1,500,000-с 1,999,999	55	95,723,876
7	2,000,000-с 2,999,999	58	142,656,130
8	3,000,000-с 3,999,999	45	154,699,135
9	4,000,000-с 4,999,999	31	139,241,994
10	5,000,000-с 7,999,999	29	148,086,584
11	8,000,000-с 9,999,999	3	25,081,830
12	10,000,000-с	1	11,070,000
Нийт		966	1,143,361,241

6.4 жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдалт

Хүснэгт 6.6. Жолоочийн даатгалд хамрагдалт

д/д	Үзүүлэлт	2023.08.01- 2023.08.31
1	Даатгалын гэрээний тоо	62,245
2	Даатгалын хураамж /төг/	3,724,306,037
3	Нөхөн төлбөр авсан тоо	966
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	1,143,361,241
5	Дундаж хураамжийн дүн/төг/	59,833
6	Дундаж нөхөн төлбөрийн дүн /төг/	1,183,604

6.5 Даатгалын зуучлагч компани

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компаниас **2023 оны 8-р сард** зуучлагч 29 компани 22,204 даатгалын гэрээ байгуулж, 1,26 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна. 2023 оны 8-р сард нийт гэрээний тоонд эзлэх хувь 35,7%, нийт хураамжийн дүнд эзлэх хувь 33,9% байна.

Хүснэгт 6.7. Жолоочийн даатгалын гэрээ /Зууч компаниар/

№	Даатгалын зууч компани	Даатгалын гэрээ	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Сүрэг хараацай	2,818	165,099,876
2	Смарт брокерс	1,264	66,475,442
3	ХААН Банк	39	1,382,765
4	Лоялти Солюшн	663	35,020,198
5	Эрсдэлийн шийдэл	2,520	165,016,905
6	Ачит-Ундарга	76	3,495,736

7	Төрийн банк	1,029	40,995,918
8	Дархан шаркс ХХК	41	2,160,012
9	Монгол бичээч	253	17,032,720
10	Дэвжих дэлгэрэх	219	13,251,027
11	ХАС банк	19	952,974
12	МАСТЕР ШИЙДЭЛ	271	13,578,177
13	ХХБ	182	10,796,117
14	LBBrokerage ХХК	85	4,420,900
15	Си Эн Эн Икс	2,820	158,336,514
16	Цагаан гэрэлт	726	43,255,653
17	Тод Капитал	1,058	55,868,869
18	Нэйшнл Эженси	552	48,711,487
19	МІВ	49	1,191,300
20	Эм Жи Ай Би ХХК	522	31,356,765
21	Амарди дижитал ХХК	525	32,426,229
22	Дэвжих зууч ХХК	1,530	84,840,579
23	Ваясьню Солюшин ХХК	6	412,446
24	Эн И Би Консалтинс ХХК	237	12,238,982
25	Асимон	1,904	84,495,170
26	Цахим капитал ХХК	1,470	84,654,844
27	ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК	4	229,046
28	НЭЙШНЛ ИНШУРАНС БРОКЕРЭЙЖ СЕРВИСЕС	3	70,950
29	Онч цэгц ХХК	1,319	82,829,752
Нийт дүн		22,204	1,260,597,353

6.6 Жолоочийн даатгалд хамрагдсан тээврийн хэрэгслийн судалгаа

2023 оны 8-р сард “В” ангиллын тээврийн хэрэгслийн гэрээ хамгийн их буюу 53,729 байгуулагдаж, 2,9 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлсэн байна. Хүснэгт №8. Тээврийн хэрэгслийн ангиллаар

№	Зүйл /Ангилал/	Даатгалын гэрээний тоо	Даатгалын хураамжийн дүн
2	A	445	10,082,742
3	B	53,729	2,923,890,883
4	C	5,001	637,048,337
5	D	890	94,830,454
6	M	514	16,418,250
7	Бусад	4	442,260
	Нийт	60,583	3,682,712,926

/ Мэргэшсэн жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн ороогүй болно./**

Долоо. Татварын байгууллагын мэдээлэл

ТатЕГ-аас мэдээлэл авч оруулах

Найм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрмийн хэрэгжилтийг хангах хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд стратегийн 4 зорилтын хүрээнд 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний тоо
1.	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21
2.	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	27
3.	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	19
4.	“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	13

НИЙТ	80
-------------	-----------

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 80 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хэрэгжсэн 16, 90 хувийн хэрэгжилттэй 5, 70 хувийн хэрэгжилттэй 15, 50 хувийн хэрэгжилттэй 12, 30 хувийн хэрэгжилттэй 24, тасарсан 8 арга хэмжээ байгаа ба төлөвлөгөөний хэрэгжилт 55.3 хувьтай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтоор нь ангилбал:

№	Зорилт	Нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн хувиар						Нийт хувь
			100	90	70	50	30	0	
1	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	21	5	4	5	-	6	1	66.2
2	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт	27	6	1	5	7	7	1	59.3
3	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	19	3	-	3	-	8	5	39.5
4	"Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	13	2	-	2	5	3	1	52.3
Нийт		80	16	5	15	12	24	8	55.3

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулбал:

№	Төлөвлөсөн зорилт, арга хэмжээ	2021 он	2022 он	Өсөлт/бууралт
1.	Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах зорилт	70.9	66.2	-4.7
2.	Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос	66.9		-7.6

	үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах зорилт		59.3	
3.	Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилт	47.5	39.5	-8
4.	“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилт	47.8	52.3	4.5
	Дундаж хувь	58.3	55.3	-3

Дөрөв. Дүгнэлт.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 55.3 хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэгдсэн.

Төлөвлөгөөнд тусгагдсан 80 арга хэмжээнээс 44 арга хэмжээ буюу 55 хувь нь 50-аас доош хувийн хэрэгжилттэй байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлогын 55 байгааг харуулж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, үр дүн муутай байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзэж байна. Үүнд:

- Төсөв, санхүүжилтгүй ажлууд төлөвлөгөөнд тусгагдсан;
- Удирдлага, зохион байгуулалт сул;
- Эрх зүйн баримт бичгийг батлуулах ажил удаашралтай, цаг хугацаа их шаарддаг;
- Салбар хоорондын уялдаа муу;
- Бусад гадаад хүчин зүйл (дэлхий нийтэд тархсан цар тахал, эдийн засгийн хүндрэл, олон улсын байдал)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулахтай холбоотой хууль, дүрэм, журам, стандарт, норм боловсруулах болон судалгаа, шинжилгээ хийх ажлууд удаашралтай байна. Жишээ дурдвал:

- “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04” -ийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх;
- Зам тээврийн осол, зөрчлийг бүртгэх нэгдсэн системийг нэвтрүүлж, судалгаа, шинжилгээ хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох;
- Замын хөдөлгөөний ноцтой зөрчсөн, замын хөдөлгөөнийн түгжрэл сааталд нөлөөлөх, урсгал сөрсөн, уулзвар руу улаан гэрлээр орсон зэрэг үйлдэлд жолоодох эрх хасах эрх зүйн тогцтолцоог бий болгох;

-Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бага наснаасаа ЗХД үзэж, жолоодлогын дадлага хийж, 18 нас хүрэхдээ жолоочийн шалгалт өгдөг байх нөхцөл бүрдүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийх;

-Зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, байрлал тогтоох техникийн шийдэл, журам боловсруулах;

-Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох судалгаа хийх;

-Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ олон улсын жишиг аргачлал ашиглан, судалгаа тооцоо хийж гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас гадна, гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх.

Мөн Автотээврийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудад замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангах талаар тодорхой зохицуулалтыг тусгасан ч дээрх хуулиуд УИХ-аар хэлэлцэгдэхгүй удааширснаас хууль батлагдсаны дараа даган гарах дүрэм, журам батлагдаагүй, эрхзүйн орчин бүрдээгүйгээс төлөвлөгөөнд тусгагдсан хэд хэдэн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн тоог бууруулах, Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн паркийг шинэчлэх, зам тээврийн ослын улмаас хохирсон иргэдэд тусламж үзүүлэх тогтолцоог бүх суурин газарт бий болгох, жолоочийн шалгалт авахад хүний хүчин зүйлийг багасгах, зам, тээврийн төлөвлөлтийг хот төлөвлөлттэй уялдуулах, зам тээврийн ослыг шинжлэн шалгах үйл ажиллагааг бий болгох ажлууд хангалтгүй байна.

Зам, тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 2020 онд 430 байсан бол 2021 онд 383 болж 10.9%-иар буурсан. Гэтэл 2022 онд энэ тоо 539 болж 40.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл өндөр байгаад бүх шатны байгууллага анхаарлаа хандуулж, шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэн, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” 12, “үр дүнгүй” 32, нийт 44 арга хэмжээг зорилтоор нь ангилж үзвэл:

- Зам тээврийн ослыг 50 хувь бууруулахтай холбоотой 7;
- Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулахтай холбоотой 15;
- Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэхтэй холбоотой 13;

- “Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулахтай холбоотой 9 арга хэмжээ байна.

Тасарсан 8 арга хэмжээ байна. Үүнд:

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
1	Сургууль, цэцэрлэгийн орчинг хөдөлгөөний эрчим ихтэй авто замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглах.	Сургууль, цэцэрлэгийн орчин болон ачаалал ихтэй гудамж, авто замын аюулгүй байдал хангагдсан байна.	
2	Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх жишиг төвийг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих замаар байгуулах асуудлыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.	Эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Улаанбаатарт 1, орон нутгийн хэмжээнд 1-ээс багагүй төвийг байгуулсан байна.	Тус төвийг байгуулах 5 га газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр "Дэмжлэг хүсэх тухай" 01/1459 дугаартай албан бичгийг БХБ-ын Сайдад 2022.04.04-ний өдөр, 03/1879 дугаартай албан бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022.04.26-ны өдөр тус тус хүргүүлсэн. Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын хэсэгчилсэн төлөвлөгөөнд “Тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн шалгалтын нэгдсэн төв” байгуулах 5 га газрыг тусгуулахаар шийдвэрлэсэн. 2023 онд газар болон хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр төлөвлөөд байна.
3	Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад импорт-оношлогоо үйлчилгээ-засвар-техникийн хяналтын бүх шатанд даатгалын цогц систем бий болгоно.	Жолоочийн даатгалын тухай хуульд холбогдох өөрчлөлт орж хэрэгжсэн байна	Жолооч болон тээврийн хэрэгслийн даатгалын тогтолцоог сайжруулах үүднээс Сангийн сайдаас ирүүлсэн “Даатгалын тухай хууль”, “Даатгалын зуучлалын тухай хууль”, “Жолоочийн даатгалын тухай” хуулиудад холбогдох саналыг бэлтгэн, 01/1160 дугаар албан бичгээр 2023.03.16-ны өдөр хүргүүлсэн. Хуулийн төслүүд ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэгдэхээр хүлээгдэж байна.
4	Иргэдийг хувийн автомашинаас татгалзах зогсоол, зорчилтын менежментийн	Авто зогсоолын тухай хууль, хөдөлгөөний ачаалал ихтэй замд төлбөр ногдуулах эрх	Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулан БХБ-ын сайдын хэдэн оны? 7 дугаар сарын 5-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хуулийн төсөлд холбогдох

	системийг боловсруулж мөрдүүлж эхэлнэ.	зүйн бодлого батлуулж хэрэгжүүлнэ.	заалтыг тусгахаар шийдвэрлэсэн. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах тухай хуулийн төсөлд зогсоолын менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой 1 бүлэг заалтыг тусгахаар холбогдох саналыг 2023.02.02 -ны өдөр 02/541 тоот албан хүргүүлсэн. Хуулийн төсөл нь ЗГ, УИХ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.
5	Хот төлөвлөлтийг боловсронгуй болгох, дахин төлөвлөлт хийх, хэсэгчилсэн төлөвлөлт хийх, замналыг шинэчлэх замаар нийтийн тээврийн шуурхай байдлыг хангана.	Нийтийн тээврээр зорчих нь хувийн автомашинаар зорчих хугацаанаас 2 дахин ашигтай байх нөхцөл бүрдсэн байна.	
6	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийх;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх чиглэлээр судалгаа хийгдсэн байна.	ЗХАБ-д аудит хийх судалгааг төслийн хүрээнд 2016 онд АХБ-аар, зөвлөх үйлчилгээний хүрээнд 2017 онд Зам тээврийн хүрээлэн НҮТББ-аар тус тус хийлгэж, ЗТХЯ хүлээн авсан. Эдгээр судалгаанд үндэслэн ЗХАБ-д аудит хийх жишиг аргачлал боловсруулж, ЗТХС-ын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.
7	Уул уурхайн ЗХАБ-ын аудит хийж, шаардлагатай тоног төхөөрөмж, тэмдэг тэмдэглэлээр хангана.	Жил бүр уул уурхайн 1-ээс доошгүй замд аудит хийж, холбогдох дүгнэлтийн дагуу өөрчлөлт хийсэн байна.	ЗХАБ-ын аудит хийх эрх зүйн орчин бүрдээгүй байгаа тул эхний ээлжинд Дархан-Улаанбаатар, Улаанбаатар-Дархан чиглэлийн олон улсын авто замд хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийх Ажлын хэсгийг ЗТХЯ-ны ТНБД-ын А/38 дугаар тушаалаар 2023.03,27-ны өдөр байгуулан ажиллаж байна.
8	Тээврийн ухаалаг системд суурилсан эрэлтийн удирдлагын системийг бий болгоно;	Зорчигч, ачаа урсгалын судалгаа хийж эрэлт, хэрэгцээнд суурилсан тээвэрлэлт хийгдэж эхэлсэн байна.	

Тав. Зөвлөмж

салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа сул байна. Зам, тээвэр, Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Барилга хот байгуулалт, Боловсрол, шинжлэх ухааны салбаруудын манлайлал шаардлагатай

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг Улаанбаатар хотын болон аймгийн төвүүдийн ерөнхий төлөвлөгөө, Автозамын мастер төлөвлөгөө, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөж хэрэгжилтийг хангах;

2. НҮБ-аас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 5 тулгуурт 12 гол зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагууд, ялангуяа Зам, тээвэр, Эрүүл мэнд, Хууль зүй, дотоод хэрэг, Барилга хот байгуулалт, Боловсрол, шинжлэх ухааны салбарууд манлайлан ажиллах, хамтын ажиллагааг сайжруулах, уялдаа холбоог хангах;

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн гишүүн бүр замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой өөрсдийн салбарын чиг үүргийг хариуцан, салбартаа уг асуудлын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах ажилтан, албан тушаалтныг томилох, эдгээр албан тушаалтнууд ЗХАБҮЗАА-тай байнгын хамтын ажиллагаатай ажиллах;

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг улсын хэмжээнд хангахын тулд шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг салбар бүрт урьдчилан тооцоолж төлөвлөх, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж хэвших;

5. Орон нутгийн замын хяналтыг сайжруулах, зам тээврийн осол, зөрчил гарах нөхцлийг бууруулах хүрээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглан хяналтын механизмыг зардал багатайгаар зохион байгуулах ажлыг төлөвлөх;

6. Зам тээврийн осол, зөрчлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, ашиглах;

7. Замын хөдөлгөөний аюулгүй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх аудитын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх, авто замын төлөвлөлтийн шатнаас эхлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудитыг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;

8. Олон улсын хэмжээнд хэрэгжиж буй Монгол улсад ашиглах боломж бүхий шилдэг стандарт, норм, дүрмийг нутагшуулах, ялангуяа суурин газарт явган зорчигч амь насаа алдах явдлыг бууруулах, арилгах хүрээнд “Явган хүний гарц”-ын стандартыг яаралтай шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангах;

9. Улаанбаатар хот болон төв суурин газрын авто замын хөдөлгөөний төлөвлөлт, зохион байгуулалтад цогц шийдэл боловсруулж хэрэгжүүлэх;

10. Нийтийн хэрэгцээний бус болон уул уурхайн замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах харилцааг бүрдүүлэх;

11. Хяналт-шинжилгээний зөвлөмжийг 2023 онд хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн байна.